

## **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР**

Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.3 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4, 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Монголбанкны Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн Удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

### **Хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага:**

- банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай;
- Худалдаа, хөгжлийн банк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч биш байх;
- Худалдаа, хөгжлийн банк, түүний нэгдлийн оролцогчид сүүлийн таван жилийн хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтан, сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байгаагүй;
- Худалдаа, хөгжлийн банкны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээс хамаарч урамшуулал авч байгаагүй, авдаггүй байх;
- Худалдаа, хөгжлийн банкны үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүсээгүй байх;
- төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх;
- эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх;

- Худалдаа, хөгжлийн банк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй холбогдох этгээд биш байх;
- Худалдаа, хөгжлийн банк, түүний нэгдлийн оролцогчид сүүлийн таван жилийн хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтан, сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байсан этгээдтэй холбогдох этгээд биш байх.

### **Бүрдүүлэх материал:**

1. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт;
2. Товч намтар (Ажлын туршлага, мэргэжил, мэргэшлийг дурдсан байх);
3. Ажил байдлын тодорхойлолт (ажил эрхэлдэг байгууллагаасаа тодорхойлолт авах);
4. Өмнө нь ажиллаж байсан газраас ажил байдлын талаарх лавлагаа (Тавигдах шаардлагын 1-р заалтыг хангаж буйгаа нотлох);
5. Боловсролын диплом, үнэмлэх, бусад сургалт семинарт хамрагдсан гэрчилгээ, сертификатын хуулбар;
6. Иргэний үнэмлэхийн хуулбар;
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын лавлагаа;
8. Шүүхийн лавлагаа (Шүүхийн төрөлжсөн архиваас).
9. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэх тухай лавлагаа.

### **Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаа, цахим хаяг:**

Сонгон шалгаруулалтад орох иргэний материалыг 2023 оны 06 сарын 26-ны өдрийн 15:00 цаг хүртэл Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албанд хэвлэмэл байдлаар эсхүл [boardoffice@tdbm.mn](mailto:boardoffice@tdbm.mn) цахим шууданд цахим хэлбэрээр хүлээн авна.